



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.10 № 03/553

танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын баримт бичигт
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ЭМЯ/20240101007 дугаартай Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилга, 80 ор (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) ажлын тендер шалгаруулалтын баримт бичигт захиалагчаас магадлалын дүгнэлтийн нэгтгэл, ажлын төсөв ирүүлсэн тул нэмэлт, өөрчлөлтийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалын батлагдсан Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 2.7 дахь хэсэг, тендер шалгаруулалтын баримт бичгийн I бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 11.1, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн хүргүүлж байна.

Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд:

- ТШЗ 26.1: Тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэл
- ТШЗ 26.2: Тендер нээх хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 09 цаг 30 минут болсныг үүгээр мэдэгдэж байна.

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт "Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ." гэсний дагуу тендер ирүүлнэ үү.